



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 3 сарын 19 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалт зохион байгуулах,
гэрчилгээ олгох журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1.“Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалтад хамрагдах төрийн албан хаагчдын мэдээлэл”-ийн маягыг 2 дугаар хавсралтаар, “Сонгуулийн хороодод ажиллах ажилтны гэрчилгээ”-ний загварыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү журмын хэрэгжилтийг хангуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Ц.Болдсайхан/-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах ажилтны мэдээллийн сан бүрдүүлэх, сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журам батлах тухай” 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА *Ч. Содном* Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Ц. Болдсайхан* Ц.БОЛДСАЙХАН



000021

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн
10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

СОНГУУЛИЙН ХОРООДОД АЖИЛЛАХ АЖИЛТНЫ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сонгуулийн хороодод ажиллах ажилтнуудад сонгуулийн хууль тогтоомжийн талаар сургалт /цаашид “сургалт” гэх/ зохион байгуулах, гэрчилгээ олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Сургалтад төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагч /цаашид “төрийн албан хаагч” гэх/ хамрагдана.

1.3. Сургалтын хөтөлбөрийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга батална.

1.4. Сонгуулийн тухай хууль тогтоомж шинэчлэн батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд сургалтын хөтөлбөрийг шинэчилж, гэрчилгээ авсан төрийн албан хаагчдыг энэ журамд заасны дагуу давтан сургалтад хамруулж болно.

Хоёр. Сургалтад хамрагдах төрийн албан хаагчдын мэдээлэл хүлээн авах, бүртгэх

2.1. Сонгуулийн ерөнхий хороо сургалтад хамрагдах төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдыг бүртгэх тухай өөрийн цахим хуудсаар мэдээлнэ.

/Энэ хэсэгт Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 07 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./

2.2. Сургалтад хамрагдах төрийн албан хаагчийн хүсэлтийг Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсаар хүлээн авна.

/Энэ хэсгийг Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 07 дугаар тогтоолоор нэмсэн./

2.3. Төрийн албан хаагч цахим бүртгэлд бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг хавсаргана:

/Энэ хэсгийг Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 07 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./

2.3.1. иргэний үнэмлэхийн хуулбар;

2.3.2. төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалд томилсон шийдвэрийн хуулбар.

2.4. Цахим бүртгэлд оруулсан баримт бичиг, мэдээллийн үнэн зөвийг тухайн албан хаагч өөрөө хариуцана.

/Энэ хэсгийг Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 07 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./

2.5. Сонгуулийн ерөнхий хороо шаардлагатай гэж үзвэл бүртгэлд хамрагдсан төрийн албан хаагчийн мэдээлэл, баримт бичгийг нягтлан шалгах зорилгоор нэмэлт мэдээлэл авч болно.

/Энэ хэсгийг Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 07 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./

2.6. Сонгуулийн хороод доод шатны сонгуулийн хороодыг байгуулах үед гэрчилгээтэй төрийн албан хаагчдын нөөц хангалтгүй тохиолдолд сургалтад

хамруулах төрийн албан хаагчдын мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.7. Сонгуулийн ерөнхий хороо энэ журамд заасны дагуу хүлээн авсан төрийн албан хаагчдын мэдээлэл, баримт бичгийг цаасан болон цахим хэлбэрээр хадгална.

2.8. Сургалтын цахим бүртгэлийн програм, түүний аюулгүй ажиллагааг Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төв хариуцан ажиллана.

/Энэ хэсгийг Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 07 дугаар тогтоолоор нэмсэн./

Гурав. Сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох

3.1. Сургалтыг дараах этгээд зохион байгуулна.

3.1.1. Сонгуулийн ерөнхий хороо;

3.1.2. аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба;

3.1.3. аймаг, нийслэлийн сонгуулийн хороо;

3.1.4. сум, дүүргийн сонгуулийн хороо.

3.2. Сургалтыг энэ журмын 3.1-д заасан этгээд зохион байгуулахдаа сургалт зохион байгуулах эрх бүхий дүрэмтэй төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно.

3.3. Сургалтыг аймаг, дүүрэгт, эсхүл бүсчилсэн байдлаар танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

3.4. Энэ журмын 3.1.2-3.1.4-т заасан этгээд сургалт зохион байгуулахдаа Сонгуулийн ерөнхий хороонд урьдчилан мэдэгдэх бөгөөд сургалт зохион байгуулсан тухай тайлан, холбогдох баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

3.5. Сонгуулийн ерөнхий хороо сургалт зохион байгуулах сонгуулийн хороодыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

3.6. Сонгуулийн ерөнхий хороо сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдад гэрчилгээ олгох бөгөөд гэрчилгээтэй төрийн албан хаагчдын жагсаалтыг цахим хуудастаа байршуулна.

/Энэ хэсэгт Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 07 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./

3.7. Гэрчилгээ нь улсын хэмжээнд нэгдсэн дугаартай байна. Гэрчилгээг гээгдүүлж, үрэгдүүлсэн тохиолдолд тухайн албан хаагчийн хүсэлтийг үндэслэн нэг удаа нөхөн олгож болно.

/Энэ хэсэгт Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 07 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан./

3.8. Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалтыг зохион байгуулахад тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.

/Энэ хэсэгт Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 07 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан./

3.9.Төрийн болон төрийн бус байгууллага, улс төрийн нам, эвсэл болон бусад этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу сонгуулийн тухай хууль тогтоомжийн сургалтыг зохион байгуулж болно.

Дөрөв. Хариуцлага

4.1.Сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэ журамд заасныг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн
10 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

СОНГУУЛИЙН ХОРООДОД АЖИЛЛАХ АЖИЛТНЫ
ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО



ГЭРЧИЛГЭЭ

Дугаар

.....-ны нь /РД:/

сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалтад хамрагдсан тул

ГЭРЧИЛГЭЭ олгов.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
дарга

/тамга/

/...../

20 ... оны дугаар сарын-ны өдөр

*Тайлбар: Гэрчилгээ нь **улсын хэмжээнд** нээгдсэн дугаартай байна.*